

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
үйлчилгээний төвийн даргын 2025 оны 09..
дүгээр сарын 29 -ний өдрийн А/37 дугаар
тушаалын 8-р хавсралт

1116131983 5007643

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны
"Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон
тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги,
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн
хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 7
дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр,
нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09
дүгээр сарын 04-ний өдрийн "БНСУ дахь
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
үйлчилгээний төвийн зохион байгуулалтын
бүтэц, орон тоо, албан тушаалын
жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/169
дүгээр тушаал

Дагаж мөрдөх огноо:

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр

Байгууллагын нэр:

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын үйлчилгээний төв

Нэгжийн нэр:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг

Албан тушаалын нэр:

Нийгмийн хамгааллын үйлчилгээ,
олон соёлт гэр бүл, хүүхдийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээ, ТҮ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

БНСУ, Сөүл хот, Жүнгү дүүрэг, Тэгэру 324,
Сон-ву барилга 4 давхар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо"-ны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх, хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тус улсад оршин сууж буй хүүхэд, олон соёлт гэр бүлийн асуудлыг хариуцах чиг үүргийн хүрээнд үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. БНСУ-д хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцоогоор ирж ажиллаж буй хөдөлмөрийн гэрээт ажилчдын гэрээний биелэлтийг хангуулах, дэмжлэг үзүүлэх, БНСУ-д ажиллаж буй Монгол Улсын иргэдийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх
2. БНСУ-д оршин сууж буй хүүхэд, олон соёлт гэр бүлд холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, арга хэмжээ хэрэгжүүлэх
3. БНСУ-д оршин сууж буй монгол иргэдэд хоёр улсын хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, арга хэмжээ хэрэгжүүлэх
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр	
			Туслах Гүйцэтгэх Хянах Шийдвэрлэх	Т Г Х Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. БНСУ-д ажиллаж буй иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаарх эрх зүйн зөвлөгөө мэдээллийг танхим, утас, цахим, явуулын үйлчилгээ хэлбэрээр хүргэх, хөдөлмөрийн харилцаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, орчуулгын үйлчилгээ үзүүлэх	Үйлчилгээ үзүүлсэн байна.		Г
	2. Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж, нутаг буцах ажилчинд нутаг буцах зардал, 13 дахь сарын цалингаа авахад нь дэмжлэг үзүүлэх	Даатгалын буцаан олголт авахад дэмжлэг үзүүлсэн байна.		Г
	3. Үйлдвэрлэлийн болон гэнэтийн осолд өртсөн иргэдэд нөхөн төлбөр авахад нь дэмжлэг үзүүлэх	Нөхөн төлбөр авахад дэмжлэг үзүүлсэн байна.		Г
	4. Хөдөлмөрийн гэрээт ажилчдад сургалт зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үр чадвартай ажилчны виз рүү хөрвөх, хууль бусаар оршин суухаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх	Мэдээллээр хангасан байна.		Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. БНСУ-д оршин сууж буй хүүхэд, олон соёлт гэр бүлд хоёр улсын холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээллээр өгөх	Зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.		Г

	2. БНСУ-д оршин сууж буй хүүхэд, олон соёлт гэр бүлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх, тухай бүр баяжилт хийх	Судалгаа гаргаж, мэдээллийн санг тогтмол шинэчилсэн байна.	Г
	3. Хүүхэд, олон соёлт гэр бүлд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулсан байна.	Г
	4. Суугаа орны хүүхэд, олон соёлт гэр бүлийн талаарх хэрэгжүүлж буй бодлого, хууль, тогтоомжийг судлах, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах	Санал боловсруулж танилцуулсан байна.	Г
	5. Хүүхэд өсвөр үеийнхнийг цахим орчны болон бусад сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, холбогдох байгууллагатай хамтран	Арга хэмжээ зохион байгуулсан байна.	Г
	6. Олон соёлт гэр бүлийн эрх зүйн харилцаатай холбоотой аливаа асуудлыг суугаа орны хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. БНСУ-д оршин сууж буй монгол иргэдэд хоёр орны нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар хууль тогтоомжийн зөвлөгөө мэдээлэл өгөх	Зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Г
	2. БНСУ-д оршин сууж буй монгол иргэдэд хоёр улсын нийгмийн хамгааллын үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн байна.	Г
	3. Хоёр орны нийгмийн хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлого, хууль, тогтоомжийг судлах, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах	Судалгаа хийж, мэдээллээр хангасан байна.	Г
	4. Нийгмийн хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай хамтран ажиллах, хамтын ажиллагааны хүрээнд арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг биелүүлэх	Хууль, тогтоомжийг мөрдөж ажилласан байна.	Г
	2. Эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд ажлаа төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлүүлэх, хариуцах, удирдлагыг мэдээллээр хангах	Хэрэгжилтийг хариуцаж ажилласан байна.	Г
	3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, суугаа орны хууль тогтоомжийг мөрдөх	Хууль тогтоомжийг мөрдөж ажилласан байна.	Г
	4. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г

5. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх	Хуулийн хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Г
6. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох	Хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
7. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх	Үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан байна.	Г
8. Өөрийн чиг үүрэгт хамаарах хоёр улсын холбогдох хууль тогтоомжийг судлан, үйл ажиллагаандаа ашиглах, мэдлэг чадвараа дээшлүүлэх	Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол		- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил		- Менежмент ба удирдахуй /0413/ - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /1022/ - Гэр бүл судлал /031403/ - Боловсрол/0111/ - Нийгмийн хамгаалал /092/ - Эрх зүй /0421/	
Мэргэшил		- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн чиглэлээр мэргэшсэн байх	
Туршлага		- Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Мэдээлэл дэх дутуу, алдаатай нийцтэй бус байдлыг илрүүлэх - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах - Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй	
	Асуудал шийдвэрлэх	- Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах - Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах - Болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чадвартай байх	
	Багаар ажиллах	- Хамт олонч, эерэг уур амьсгалыг бүрдүүлж, зөв хандлагыг эрхэмлэх - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох	
	Бусад	- Төрийн албан хэрэг хөтлөлт, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх - Солонгос эсхүл англи хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх - Мэдээллийн технологи, компьютерын хэрэглээний программуудыг ашиглах чадвартай байх - Хувийн зохион байгуулалт сайтай, бүтээлч санаачилгатай байх, бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар	

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1. Монгол Улсын төрийн байгууллага, яам, агентлаг, тэдгээрийн газар, хэлтсийн холбогдох албан тушаалтан, төрийн бус байгууллага
2. БНСУ дахь төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд
3. Иргэн, хуулийн этгээд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
АХЛАГЧ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ТАСГИЙН ДАРГА

..... Сэржмядагийн СҮНЧИН
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Шийдвэрийн огноо:

2025.09.29

Дугаар:

A/37

ДАРГА

Бадарчийн ЖАРГАЛМАА

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

(тамга/тэмдэг)

2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр